

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 183 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Увс аймгийн “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /П.Бат-Орших/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Тариф батлах тухай” 542 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тарифын газар /Б.Эрдэнэбулган/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

*Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны ... дугаар сарын ...ний өдрийн
... дүгээр тогтоолын хавсралт*

**УВС АЙМГИЙН УЛААНГОМ СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Увс аймгийн “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	3,200.0
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	41,300.0
		тогтмол	Төг/м ³
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,500.0
	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	29,087.0
		тогтмол	Төг/м ³
3	Төсөвт болон ҮААНБ-ын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м ³	6,750.0
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0”-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1,200.0
5	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	9,600.0
		Төг/м ³	6,750.0